



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/81

Төгөл

Өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн А/306 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын хэмжээнд 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: М.Батцогт (Тамгын газрын дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

- Б.Баярхүү (Шивлэг багийн Засаг дарга)
- Д.Пүрэвдаваа (Тоом 2-р багийн Засаг дарга)
- Х.Даваа (Мунгараг 3-р багийн Засаг дарга)
- С.Мягмардорж (Соёо 4-р багийн Засаг дарга)
- Т.Амарсайхан (Төгөл 5-р багийн Засаг дарга)
- Л.Баттогтох (Гун 6-р багийн Засаг дарга)
- Б.Батзаяа (Хэсгийн төлөөлөгч)
- Э.Даваадорж (Хэсгийн цагдаа)
- Б.Баярмаа (Мал эмнэлгийн Улсын байцаагч)
- Г.Бямбахишиг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
- А.Нансалмаа (ЕБС-ийн захирал)

Б.Нарангарвуу (ЭМТ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Амаржаргал (СӨБ-ын эрхлэгч)

Д.Агармаа (Соёлын төвийн эрхлэгч)

М.Баярсайхан (Хилийн цэргийн дарга)

Ж.Төмөрсүх (УТУТХГХЗ-ны дарга)

Б.Өсөхжаргал (Цаг уурч)

Б.Нямхишиг (СДОА-ийн дарга)

Д.Жамбал (ХААН банкны эрхлэгч)

Г.Ариунаа (Төрийн банкны эрхлэгч)

Г.Ариунбат (Эрчим хүч)

Б.Бямбацогт (Холбооны эрхлэгч)

С.Санжаа (НИК штс)

О.Цэцэгбат (Нэмэн штс)

Ө.Эрдэнэбаяр (Дэлгэрхаан штс)

Н.Тагнанжав (Буянт мал- Хөвсгөл ББН-ийн эзэн)

М.Батцэнгэл (Бэлтэс мал эмнэлэг ББН-ийн эзэн)

Б.Бат-Ерөөлт (Алаг хад далайц ББН-ийн захирал)

С.Жаргал (Хөгийн голын ундарга ХХК-ийн захирал)


Нарийн бичгийн дарга Н.Намхайбаатар (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

2. Сумын хэмжээнд өвөлжилтийн ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, албан даалгаврыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар зохион байгуулж явц үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Батцогт)-д даалгасугай.

ДАРГА  М.БАТБАЯР
9072204 6715114404

Сумын Засаг даргын 2024 оны 08
дугаар сарын 26-ний өдрийн А/... тоот
захирамжийн нэгдүгээр хавсралт



ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хийж, бүх боломж бололцоог ашиглан нөөц бүрдүүлэх, өвлийг өнтэй давах нөхцөлийг хангах.

1. 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах, өөр аймаг болон өөрийн сумын Засаг дарга нартай гэрээ 09 сард багтаан гэрээ хийсэн байх. Хариуцах эзэн: Сумын Засаг дарга

2. Сум дундын өвс тэжээлийн фондонд аймгийн мал хамгаалах сангаас хувиарласан өвс тэжээлийг 09 сарын 20-ны дотор багтаан татаж байршуулж, дээрээс нь нэмж бүрдүүлэх нөөцийг баг, сумын түвшинд зохион байгуулах. Хариуцах эзэн: Байгууллага болон багын Засаг дарга нар.

3. Мал сүрэгт үзлэг ангилалт хянан баталгаажуулалт хийж байгаа ажлыг цаг хугацаанд гүйцэтгэх, Бог малын хээлтүүлэгч малын хүрэлцээ тохирооны судалгаа гаргаж, дутагдаж байгааг чанартай хээлтүүлэгчээр хангах арга хэмжээ авах. Хариуцах эзэн: ЗДТГ, МЭҮТ, МЭҮН-үүд

Мал аж ахуйн чиглэлээр:

4. Мал сүргийг мал эмнэлгийн намрын төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах 09 сард багтаан/ Вакинжуулалт, угаалга туулгалт, боловсруулалт, лабораторийн шинжилгээг/ хугацаанд нь технологийн дагуу чанартай хийж үр дүнг мэдээлэх. ЗДТГ, МЭҮТ, МЭҮН-үүд

5. Баг малчин өрх бүр өөрсдийн болон хашаа хорооны дулаалга ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг эртнээс сайтар 09 сард зохион байгуулах. Хариуцах эзэн: багийн Засаг дарга нар болон МЭҮН-үүд болон МЭҮТ

6. Байгаль цаг агаарын аюултай үзэгдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг цаг алдалгүй малчид иргэдэд хүргэх. Хариуцах эзэн: Цаг уурч

7. Малд үзлэг ангилалтыг цаг хугацаанд нь гүйцэтгэн заазлатыг хийж зах зээлд худалдан борлуулах ажлыг зохион байгуулах, судалгаа гарган мэдээллэх 09-10 саруудад багтаан хийж гүйцэтгэх. Хариуцах эзэн: МЭҮТ, МЭҮН-үүд болон багийн Засаг дарга нар.

8. Халдварт болон празит өвчний голомтын судалгааг баг бүрээр ажлыг 09 сар хийж гүйцэтгэнэ. Хариуцах эзэн: МЭҮТ, МЭҮН-үүд

9. Баг бүрийн бэлчээрийн ургац даац багтаамжийг тодорхойлох ажлыг 08 сарын дунд ба сүүлийн 10 хоногт зохион байгуулах. Хариуцах эзэн: МАА-н мэргэжилтэн.

Төв суурин газар албан байгууллагууд:

10. Цаг үеийн ажлын мэдээ, тайланг үнэн бодитойгоор цаг хугацаанд нь гаргаж ирүүлэх тогтмол бэлэн байх тухайн цаг үед. Хариуцах эзэн: Тухайн хариуцсан албадууд.

11. Албан байгууллагын түлээ, түлшийг бүрэн татаж нөөцлөх ажлыг 10 сард багтаан хийж гүйцэтгэх. Хариуцах эзэн: Албан байгууллагууд.


12. Байгууллагын засвар үйлчилгээг бүрэн дуусгаж, дулаалга, халаалт, эрчим хүчний асуудлыг бүрэн шийдэх ажлыг 09 сард багтаан хийж гүйцэтгэх. Хариуцсан эзэн: Албан байгууллагууд

Газар тариалангийн чиглэлээр:

13. Хүнсний ногоо, төмс, байцаа, лууван, жимс жимсгэнэ хураалтын мэдээг гаргах ажлыг 09 сард хийж гүйцэтгэнэ. Хариуцах эзэн хувь хүн, аж ахуйн нэгжүүд.

14. Орон нутгийн орлого нөөц бүрдүүлэх чиглэлээр бүтээлч ажил зохион байгуулах ажлыг 8,9,10, саруудад хийж гүйцэтгэнэ. Хариуцах эзэн: ЗДТГ.

Сумын Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/... дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралт



АЛБАН ДААЛГАВАР

Багийн засаг дарга байгууллагын дарга эрхлэгч нарт:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн А/306 дугаар захирамжийг тус тус үндэслэн бүх албан байгууллага, ААН, баг, малчид иргэдийн өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангуулах ажлыг зохион байгуулж хариуцлагатай ажиллах хүрээнд дараах албан даалгавар хүргүүлж байна. Үүнд:

1. Баг байгууллагын хүрээнд өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж хяналт тавьж ажиллах
2. Сумын түвшинд сумын аюулгүй нөөцөд бүрдүүлвэл зохих өвс, тэжээлийн нөөцийг 09 дүээр сарын 30-ны өдрийн дотор бэлтгэж, сумын өвсний фондод байршуулах,
3. Хорио цээрийн дэглэм тогтоосон үед сумдад хүн, мал, амьтны хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний тээвэрлэлт, худалдаанд олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байх, мал сүргийг дархлаажуулах ажлыг богино хугацаанд гүйцэтгэх
4. Байгууллагууд гадаад дотоод өнгө үзэмж орчны стандарт эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцлийг бүрдүүлэх, дутуу хийсэн зүйлийг гүйцээх, дулаалга, халаалтын бэлэн байдлыг бүрдүүлэх, машин техник тоног төхөөрөмжийн ажиллах нөхцийг бүрдүүлэх
5. Байгууллага бүр ариутгал, халдвар гүйжүүлэлтийг тогтмол хийж бэлэн байдлыг хангаж ажиллах ,
6. Түлээ, түлш бэлтгэх ажлын дутууг гүйцээх
7. Мал сүргийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, угаалга, тариалга, туулгалтанд бүрэн хамруулж дуусгах.
8. Өвөлжөө, хаваржааны хашаа саравчийг засах сэлбэх ажлыг эрчимжүүлэх, үр дүнг тооцох
9. Отор хийх өрхийн бүртгэлийг нэг бүрчлэн гаргах, мэдээллэх
10. Цаг уурын мэдээллийг цаг тухайд бүрэн хүргэж байх нөхцлийг хангах
11. Малчид гар тэжээл бэлтгэх, нөөцлөх ажлыг баг бүрт сайн зохион байгуулах .

Сумын хэмжээнд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажилд идэвхтэй хариуцлагатай оролцох. Бэлтгэх өвсний хуваарь:

- ЗДТГ-2 машин Хаан банк-1 машин
- ЕБС-3 машин Төрийн банк-1 машин
- ЭМТ-1 машин Соёлын төв -1 машин
- СӨБ- 1 машин СДОА-1 машин
- УТУТХГ-1 машин 6-н баг тус бүр 1, 1 машин
- Хилийн цэрэг-1 машин
- Жич Баг байгууллага дээрээ өвс бэлтгэх ажлыг зохион байгуулан сумын өвсний фондод 2024 оны 09 дүгээр сарын 30-ны дотор хүлээлгэн өгнө.1 машин өвсийг тооцож хүлээн авна.